

Анги судлагдхуун			ТҮҮХ 12 ДУГААР АНГИ																											
Шалгалт үргэлжлэх хугацаа			80 минут																											
Даалгаврын хэлбэр			Сонгох даалгавар								Задгай даалгавар								Нийт											
№	Агуулга	Дэд агуулга	Мэдлэг ойлголт		Чадвар		Хэрэглээ		Нийт		Мэдлэг ойлголт		Чадвар		Хэрэглээ		Нийт													
			Даалгаврын тоо	Оноо	Даалгаврын тоо	Оноо	Даалгаврын тоо	Оноо	Даалгаврын тоо	Оноо	Эзлэх хувь	Алхамын тоо	Оноо	Алхамын тоо	Оноо	Алхамын тоо	Оноо	Даалгаврын тоо	Алхамын тоо	Оноо	Эзлэх хувь	Даалгаврын тоо	Оноо	Эзлэх хувь						
1	XVII-XX зууны эхэн үеийн монгол	Манжийн ноёрхол дахь монгол орон	1	1					1	1	10	1	2	2	4	1	2	1	4	8	20	4	11	11,4						
		1911 оны хувьсгал					1	1	1	1																				
		Шинэ эргэлтийн бодлого			1	1			1	1																				
2	БНМАУ-ын нийгэм эдийн замгийн ,улс төр ийн байдал 1924-1990 он	Шинэ эргэлтийн бодлого	1	1					1	1	16,7											6	13	17,1						
		Ардчилсан хувьсгал			1	1			1	1																				
		Нийгэм эдийн засаг					1	1	1	1		2	3	1	2	2	3	1	5	8	20									
		Анхдугаар үндсэн хууль 1990 он ардчилсан өөрчлөлт	1	1			1	1	1	1																				
3	Монгол төрийн сэргэн мандалт 1911-1924 он	Олноо өргөгдсөн монгол улс	1	1					1	1	13,3											4	4	11,4						
		Богд хаантмонгол улс	1	1					1	1																				
		Манжий ноёрхол дахь монгол орон			1	1			1	1																				
		Богд хаантмонгол улс					1	1	1	1																				
4	Монголын өвөг түүх 800000- жилээс нтө-IV зуун	Палеолит	1	1					1	1	10	1	2	2	4	1	2	1	4	8	20	4	11	11,4						
		Неолит			1	1			1	1																				
		Хүрлийн үе					1	1	1	1																				

5	Монголын эзэнт гүрний дараах монгол улс XIV-XVII зуун	Чингисийн өмнөх үеийн монголчууд	1	1				1	1	10											3	3	8,8		
		Их монгол улс			1	1			1		1														
		Чингисийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг					1	1	1		1														
6	Монголын эзэнт гүрэн XII-XIV зуун	Хувилай хааны төрийн бодлого	1	1				1	1	10															
		Өгэдэй хааны төрийн бодлого			1	1			1		1														
		Алтан ордны улс					1	1	1		1	2	3	2	3	1	2	5	8	20		4			
7	Монголын эртний улсууд	Хүннү гүрэн	1	1				1	1	13,3	1	2	2	4											
		Жужан	1	1					1		1														
		Сяньби			1	1			1		1												4	4	11,3
		Түрэг					1	1	1		1														
8	Орчин үеийн Монгол улс 1990 оноос хойш	Ардчилсан хувьсгал	1	1				1	1	16,7															
		Эдийн засгийн өөрчлөлтүүд			2	2			2		2	1	2	2	3	2	3	5	8	20		8	13	17,1	
		Оюун санааны өөрчлөлт					2	2	2		2														
			10	10	10	10	10	10	30	30		7	12	9	16	7	12	5	23	40		35	70		
										100										100					
																								100	

ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Даалгавар №	Агуулга /даалгавар/	Зөв хариулт Хувилбар А	Зөв хариулт Хувилбар Б	Оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
1.	Манжийн ноёрхол дахь монгол орон	D	A	1	
2	1911 оны хувьсгал	A	C	1	
3	1911 он	D	A	1	
4	Шинэ эргэлтийн бодлого	C	B	1	
5	Ардчилсан хувьсгал	C	C	1	
6	Нийгэм эдийн засаг	D	E	1	
7	Анхдугаар үндсэн хууль	C	A	1	
8	1990 он ардчилсан өөрчлөлт	B	C	1	
9	Олноо өргөгдсөн монгол улс	A	D	1	
10	Богд хаантмонгол улс	A	B	1	
11	Манжийн ноёрхол дахь монгол орон	B	D	1	
12	Богд хаантмонгол улс	C	E	1	
13	Палеолит	A	D	1	
14	неолит	C	A	1	
15	Хүрлийн үе	C	C	1	
16	Чингисийн өмнөх үеийн монголчууд	D	A	1	
17	Их монгол улс	C	E	1	
18	Чингисийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг	A	A	1	
19	Хувилай хааны төрийн бодлого	B	E	1	
20	Өгэдэй хааны төрийн бодлого	C	C	1	
21	Алтан ордны улс	B	B	1	
22	Хүннү гүрэн	C	A	1	
23	Жужан	B	C	1	
24	Сяньби	C	B	1	
25	Түрэг	B	A	1	
26	Эдийн засгийн өөрчлөлтүүд	C	B	1	
27	Оюун санааны өөрчлөлт	C	C	1	
28	Ардчилсан хувьсгал ач холбогдол	D	A	1	
29	Өмч хувьчлал	E	E	1	
30	Эдийн засаг	A	D	1	

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР					
№	Агуулга	Хувилбар "А"	Хувилбар "Б"	Оноо	Хариултын тайлбар
31.A	XVII-XX зууны эхэн үеийн монгол	Монголын газар нутгийг Манж Хятадууд алдахгүйн тулд энэ бодлого хэрэгжүүлсэн	Олноо өргөгдсөн Монгол улсын Засгийн газрын Ерөнхий сайд Т.Намнансүрэн	2	Бүрэн хариулт 2 оноо дөхүүлсэн бол 1 оноо
31.B		- Хятад хүмүүсээр тариа тариулах болсон. - Улс төрийн төрийн хүрээний асуудал	- Тусгаар тогтнолоо зарласан Монгол улсын нийслэлийн нэр нийслэл хүрээ гэдэг байв . - Монголчууд 220 жил харь гүрний эрхшээлд маш хатуу бэрх зовлон эдэлсэн учир хувьсгал хийв.	4	Бүрэн бол 4 оноо дутуу бол 2 оноо
31.C		Монголчуудыг гадаад ертөнцөөс тусгаарлах бодлого	1911 оны хувьсгалын ач холбогдол харь гүрний дарлалаас гарч үндэсний эрх чөлөөгөө олж авсан ач холбогдолтой.	2	Бүрэн бол 2 оноо дөхүүлсэн бол 1 оноо
32.A	БНМАУ-ын нийгэм эдийн засгийн, улс төр ийн байдал 1924-1990 он	Монголд атар газар эзэмших үйл явдал болсон.	Монгол оронд өрнөсөн улс төрийн хилс хэрэгт өртсөн ард иргэдийн дурсгалд зориулсан.	3	Бүрэн бол 3 оноо хариулт дутуу болон дөхүүлж хариулсан бол 1,5 оноо
32.B		1959 оноос атрын анхны аян эхэлсэн	Монголын түүхэнд дэх хэлмэгдүүлэлт 1921 оноос 1960 он хүртэл үргэлжилсэн.		
32.C		Атар газар өөрийн орны нутагт хүнсний хэрэгцээг хангах болсон	Жил бүрийн 9 сарын 10 өдөр дээрх хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлдэг.	2	Хариулт тус бүрд 2 оноонд багтааж задалж тооцох Бүрэн 2 оноо, Дутуу бол 1 оноо, буруу бол 0 оноо
32.D		-Атар газар эзэмшсэнээр үржил шимтэй газар бүрт газар хагалж дараа жил нь өөр газарт хагалж болсон . -Малын бэлчээрийн талбай хомосдож байсан.	- "Онцгой бүрэн эрхт комисс улс төрийн хэрэгт баривчлан хүмүүсийг хомроглон устгаж байв. - Ард олныг ангичлан ялгаварлан,хүн хүнээ үл итгэх явдал дээд цэгтээ хүрч улс төрийн хилс хэрэгт баривчлагдан егүүтгэж ар гэр ахан дүүс,төрөл төрөгсөд найз нөхөд, нутаг усныхан хэлмэгдэлтэд өртөж байв.	3	Бүрэн бол 3 оноо хариулт дутуу болон дөхүүлж хариулсан бол 1,5 оноо
33.A	Монгол төрийн сэргэн мандалт 1911-1924 он	НТӨII зууны 2 дугаар хагас	Хүн төрөлхтний түүхэнд хамгийн удаан хэрэглэгдсэн багаж зэвсгийн материал бол чулуу юм.	2	Бүрэн хариулсан бол 1 оноо дөхүүлсэн бол 0,5 оноо
33.B		Хүннү гүрэн газар нутгаа төвшитгөсөн Найрамдалтай энх амгалан амьдрах болсон	- Монгол нутагт 800000 мянган жилийн тэртээгээс хүн суурьшин амьдрах болсон - Монгол нутагт 800 мянган жилийн өмнөөс хүн оршин амьдарч байсан нь тогтоогдсон.	4	Бүрэн хариулсан бол 4 оноо 1 даалгавар бүрэн хийсэн бол 2 оноо дөхүүлсэн бол оноо 1 оноо өгнө
33.C		НТӨ198-93 он 22 жилийн дараа	Хүмүүсийн амьдралд их өөрчлөлт гарсан энэ үеийг неолитийн хувьсгал гэнэ	2	Бүрэн бол 2 оноо хариулт 1 нь бүрэн бол 1 оноо дөхүүлсэн бол 0,5 оноо

34.A	Монголын эзэнт гүрэн XII-XIV зуун	1206 онд Онон мөрний эхэнд их хуралдайгаар Их монгол улс хуралдайгаар	<ul style="list-style-type: none"> - Хорезмыг дайлаар мордохоос өмнө хаан ширээ залгамжлагчаар -Өгэдэйг залгамжлагчаар тодруулсан. - Чингис хаан 1205,1207,1210 онуудад тангуд руу довтолж байв. 	3	Бүрэн бол 3 оноо хариулт дутуу болон дөхүүлж хариулсан бол 1,5 оноо
34.B		Тэнгэр шүтдэг	1219-1225 онд Хорезм улсыг эзлэн авсан.	3	Бүрэн бол 3 оноо хариулт дутуу болон дөхүүлж хариулсан бол 1,5 оноо
34.C		Хөрш улсуудтай эрх тэгш найрсаг бодлого явуулдаг.	Энэхүү аян дайны үр дүнд Их Монгол улсын газар нутаг баруун талын зах нь Амардарьяа Сирдарьяа мөрний сав газраар зааглагдаж байв.		
34.D		Энх тайван амар амгалан байдлыг тогтоосон			
34.E		81 том жижиг аймгийг эрхшээлдээ оруулж бүх монгол туургатнаа нэгтгэсэн учраас	Алтан аргамж Нүүдэлчдын аж ахуй гадаад харилцаандаа төрийн баримтлах бодлогыг хэлнэ.	2	Бүрэн бол 2 оноо дөхүүлж хариулсан бол 1 оноо
35.A	Орчин үеийн Монгол улс 1990 оноос хойш	Шинэ ардчилсан үндсэн хууль	Монгол улсад Ардчилсан шинэ үндсэн хуулийг 1992 оны 1 сарын 13 өдөр баталсан.	2	Бүрэн бол 2 оноо дөхүүлж хариулсан бол 1 оноо
35.B		<ul style="list-style-type: none"> • 1960 он иргэн шууд төлөөллийн байгууллагаар уламжлан нийгэм аж ахуйг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох эрхтэй • БНМАУ-ын иргэд Үйлдвэрчны эвлэл , хоршоолол,залуучууд ,биеийн тамирын эвлэл зэрэг байгууллагад нэгдэх эрхтэй • 1992 он шууд буюу төлөөллөлийн байгуулагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. • Нийтийн болон өөрсдийн ашиг сонирхол үзэл бодлын үүднээс нам олон нийтийн байгууллага байгуулах сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй . 	<ul style="list-style-type: none"> • Монгол улсад хэдэн онд анх удаа бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль 1990 онд болсон • Хүний эрх чөлөөг баталгаажуулахын тулд иргэдийн нийцтэй оролцоог хангахын тулд 	3	Бүрэн бол 3 оноо хариулт бүрийн талыг бичсэн бол 1,5 оноо нэг хариулт зөв бол 0,75 оноо авна
35.D					

1. 1911 оны 12 сарын 29 билгийн тооллын ямар жилийн хэдэн сарын хэдэн байсан бэ?
- A. Улаагчин хулгана жилийн намрын адаг сарын шинийн найман
B. Цагаагчин гахай жилийн өвлийн эхэн сарын шинийн найман
C. Цагаагчин хулгана жилийн өвлийн дунд сарын шинийн есөн
D. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн
2. Тусгаар тогтнолын төлөө Орос улсаас тусламж хүсэхээр явсан төлөөлөгчдийг нэрлэнэ үү.
- A. Чин Ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Гүн Хайсан
B. VIII Богд Жавзандамба, Чин Ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд
C. Т. Намнансүрэн, С. Магсаржав, Ж. Дамдинсүрэн
D. Бадамдорж, Магсаржав, Дамдинсүрэн
3. Монголчууд XX зууны эхэн үе ядуу буурай орон болсны гол шалтгааныг сонгоно уу.
- A. Нүүдлийн мал аж ахуй хоцрогдон аж үйлдвэр хөгжөөгүй учир
B. Гадаадаас зээл тусламж авч байгаагүй учир
C. Ноёд язгууртнууд ард иргэдээс маш их хэмжээний татвар авч байсан учир
D. Тусгаар тогтнолоо алдаж харь улсын эрхшээлд орсон учир
4. Шинэ эргэлтийн бодлогын ерөнхий агуулгаас зөвийг сонгоно уу.
- A. Эдийн засгийг сэргээн хөгжүүлэх B. Төрийн байгууламжийг өөрчлөх
C. Зүүнтний алдаатай бодлогын улмаас улсын эдийн засаг, нийгэмд бий болсон хор уршгийг арилгах D. Төр, Намын байгууллагыг урвагчдаас цэвэрлэх
5. Ардчилсан хувьсгалын хамгийн гол ололт үнэ цэнийг юу гэж тодорхойлсон байдаг вэ?
- A. Монголчууд үг хэлэх хэвлэн нийтлэх эрхтэй болсон
B. Шүтэх бишрэх, өөрийн гэсэн өмчтэй байх эрхтэй болсон
C. Сүүлийн 300 шахам жил гадаад улсын хараад байдалд байснаас гарч улс төрийн тусгаар тогтнолыг олж, хувь заяагаа өөрсдөө шийдэх болсон
D. Гадаад суралцах, өөрийн дураар аялах эрхтэй болсон
6. Тусгаар тогтносон Монгол улс хэдэн онд үндэсний мөнгөн тэмдэгттэй болсон бэ?
- A. 1921 он B. 1922 он C. 1924 он D. 1925 он
7. Анхдугаар үндсэн хуулийн төслийг боловсруулахад оролцсон Зөвлөлтийн мэргэжилтэн хэн бэ?
- A. И.Я. Коростовец B. В.И. Ленин C. П.В. Всевятский D. В.Амагаев
8. 1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд аль нь хамааралгүй вэ?
- A. Хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулсан
B. Цөөн хэдэн намууд төрийн эрхийн төлөө өрсөлдөх боломжтой болсон
C. Хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг замд шилжин орсон
D. Олон намын тогтолцоотой болж, ардчилсан сонгууль явуулах болсон
9. “Олноо өргөгдсөн Монгол улс”-ын үеийн яамдыг сайд нартай нь зөв тохируулна уу.
1. Гадаад яам A. Г. Чагдаржав
2. Сангийн яам B. Да лам Цэрэнчимэд
3. Дотоод яам C. Чин ван Ханддорж
A. 1C 2A 3B B. 1A 2C 3B C. 1A 2B 3C D. 1C 2B 3A
10. Манж амбан Сань До Хүрэннээс хэзээ хөөгдсөн бэ?
- A. 1912.12.04 B. 1911.12.04 C. 1910.12.04 D. 1911.12.29
11. Тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаад VIII Богд Жавзандамба хутагтад ямар цол өргөмжилсөн бэ?
- A. Нарангэрэлт түмэн наст Богд хаан B. Шашин төрийг хослон баригч, Нарангэрэлт түмэн наст Богдхаан
C. Монголын эзэн шашныг баригч, Нарангэрэлт түмэн наст Богд хаан
D. Хэмжээгүй эрхт Нарангэрэлт түмэн наст Богд хаан
12. XIX зууны сүүл XX зууны эхээр Хятад иргэдийг Ар Монголд олноор нь нүүлгэн, суурьшуулах болсны шалтгаанаас зөвийг сонгоно уу.
- A. Хүн амын тоог нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэх B. Монголчуудын улс төрийн эрх мэдлийг хасах
C. Монголчуудыг үндэстнийх нь хувьд цусаар уусгаж хятадчилах
D. Мал аж ахуйг сэргээх, өргөн уудам нутагт тариаланг хөгжүүлэх
13. Орчин үеийн хүн буюу “Homo sapiens sapiens” хэзээ үүсч бий болсон бэ?
- A. 100000 орчим жил B. 60000 орчим жил C. 40000 орчим жил D. 30000 орчим жил
14. Хүмүүс хэдий үеэс галыг хэрэглэж эхэлсэн бэ?
- A. Хуучин чулуун зэвсгийн эхэн үе B. Дунд чулуун зэвсгийн сүүл үе
C. Хуучин чулуун зэвсгийн дунд үе D. Шинэ чулуу зэвсгийн эхэн үе
15. “Палеолит” гэдэг нь чулуун зэвсгийн аль үеийг нэрлэж байна вэ?
- A. Шинэ чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Хуучин чулуун зэвсэг D. Хүрэл зэвсэг

16. “Монголын нууц товчоо”-нд Өгөдэй хааны 4 сайн үйл хэмээн, “... Усгүй газар худаг усыг гаргасан, бор дарснаас татгалзсан ... ” гэх зэргээр өгүүлсэн байдаг. Үлдсэн хоёр сайн үйл аль нь вэ?
A. 1. Бүх хятадыг нэгтгэсэн, 2. Бүх шашныг хүлээн зөвшөөрсөн
B. 1. Өмнөд Сүн улсыг эзэлсэн, 2. Бор гөрөөсийг хашаалсан
C. 1. Өртөө улааг байгуулав, 2. Алтан улсыг эзлэв
D. 1. Даргач тамгач нарыг суулгасан, 2. Өмнөд Сүн улсыг бүрэн эзэлсэн
17. Ираны түүхч Рашид-ад-Динаар “Судрын чуулган”-ыг бичүүлсэн хааныг сонгоно уу.
A. Аргун B. Газан C. Хүлэгү D. Өлзийт
18. Алтан ордны хаант улсын нийслэл аль нь вэ?
A. Сарай хот B. Самарканд C. Астрахань D. Бах чисрай
19. 2.Их Монгол улс хэдээс хэдэн оны хооронд оршин тогтнож байсан бэ?
A. 1206-1260 B. 1206-1264 C. 1211-1260 D. 1211-1271
20. Чингис хаан хөрш орнуудын эсрэг зэвсэглэн тэмцэж байсан нь ямар үр дагаварт хүргэсэнийг зөв тайлбарласныг сонгоно уу.
A. Элчийг доромжилсны хариуд цэрэг хөдөлгөж Их Монгол улсын тусгаар тогтнолыг зэвсгийн хүчээр хүлээн зөвшөөрүүлсэн
B. Элчийг доромжилсны хариуд цэргийн хүчээр хүн амыг хядаж Их Монгол улсын тусгаар тогтнолыг зэвсгийн хүчээр хүлээн зөвшөөрүүлсэн
C. Үл тоомсорлож байсны хариуд их цэрэг хөдөлгөж Их Монгол улсын тусгаар тогтнолыг зэвсгийн хүчээр хүлээн зөвшөөрүүлсэн
D. Үл тоомсорлосон тул хүн амыг хядаж Их Монгол улсын тусгаар тогтнолыг зэвсгийн хүчээр хүлээн зөвшөөрүүлсэн
21. Их Монгол улсын нийслэлийг шилжүүлэх болсон шалтгааныг сонгоно уу.
A. Монголоор төвлөрч Хятад улсыг захирах хялбар
B. Хятад улсыг Хятад нутгаас захирах нь хялбар
C. Монголчууд суурин иргэншилд татагдаж байсан D. Хятад улс хүн ам ихтэй байсан
22. Хүннүүд бичиг үсэгтэй байсан гэж үзэх шалтгааныг доорх өгөгдлөөс сонгоно уу.
A. Тэдний Хан улсад явуулсан захидал Хятад улсын музейд бий учир
B. Хүннү улсын түүхийг өгүүлсэн бичээс бүхий хад олдсон учир
C. Хүннүгийн булшнаас бэхийн дурсгалтай бийрний нийлүүр олдсон учир
D. Ноён уулнаас олдсон ширмэл ширдэгт тэдний бичиг үсгийн дурсгал үлдсэн байдаг учир
23. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Цамбагарав уулын хаданд сийлсэн хуягт морин цэргийн зураг нь аль улсын үед холбогдох вэ?
A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Түрэг
24. Монгол нутагт байгуулагдсан Монгол угсааны эртний улсаас хамгийн сүүлд байгуулагдсан улс аль нь вэ?
A. Хүннү B. Сяньби C. Нирун D. Хятан
25. Түрэг угсааны эртний улсуудаас хамгийн удаан оршин тогтносон нь аль вэ?
A. Уйгар B. Түрэг C. Киргиз D. Динлин
26. 1989 оны 12-р сарын 10-ны өдөр Залуучуудын соёлын ордны талбайд болсон цуглаан дээр улс төрийн ямар хүчин байгуулагдсаныг зарласан бэ?
A. Шинэ үе бүлгэм B. Монголын Ардчилсан Нам
C. Монголын Ардчилсан Холбоо D. Шинэ Дэвшилтэт Холбоо
E. Монголын Үндэсний Дэвшлийн Нам
27. БНМАУ-д олон намын оролцоо бүхий анхны ардчилсан сонгууль хэдэн онд болсон бэ?
A. 1992 он B. 1991 он C. 1990 он D. 1993 он E. 1994 он
28. 1990 оны ардчилсан хувьсгалын ач холбогдлыг тодорхойлно уу
A. НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элсэх болзлыг хангасан
B. Социалист системийн орнуудаас холдон хөндийрсөн
C. Англи, Франц зэрэг орнуудтай дипломат харилцаа тогтоох боломж нээгдсэн
D. Хүний эрх, эрх чөлөөг хангах нийгэм-улс төрийн тогтолцоонд шилжсэн
E. Социалист хөгжлийн чиг баримжааг засаж сайжруулах боломжтой болсон
29. Монгол улсад үйлдвэр, үйлчилгээний салбаруудыг ямар хэлбэрээр хувьчилсан бэ?
A. Тендер зарлаж өмчлөлийн эрхийг шилжүүлсэн
B. Гадаадын хөрөнгө оруулагчдад хувьчлах замаар
C. Үйлдвэр, үйлчилгээний газрын дарга нарт өмчлөх эрхийг шилжүүлэх байдлаар
D. Дуудлага худалдаагаар хувьчилсан E. Иргэдэд хувьцаа эзэмшүүлэх замаар
30. 1990-ээд онд Монгол улс чөлөөт үнийн тогтолцоонд шилжих болсны гол шалтгаан юу вэ?
A. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихийн тулд
B. Бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой барьж байхын тулд
C. Ард иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд
D. Төрөөс бараа бүтээгдэхүүний үнийг зохицуулахын тулд
E. Гадаад валютыг дотоод зах зээлээс шахаж гаргахын тулд

ЗАДГАЙ ДААЛГАВАР :

31. Нэгэн зүйл. Монгол газарт Шинэ засаг дэлгэрүүлэх нэрээр шалтгаалж олон иргэнийг нэн үлэмж хуруулан халхын хойд хязгаарын хэд хэдэн хошууны нутгийг зөвд нь хагалан тариа тариулж нутаглан суулгахаар нэгэнт тогтоон бүхий нь Монголын амьдралыг нэгмөсөн тасалж, харьяа хязгаар захыг батлая гэсэн санаа лавтайяа мөний тул цухалдаж хорсох билээ.

A. Монгол газарт шинэ засаг дэлгэрүүлэх болсон гэж юуг хэлж байна вэ? Асуултанд хариулж бичнэ үү.

.....

B. Энэхүү бодлогоор ямар хүмүүсээр монгол нутагт тариа тариулах болсон нийгмийн аль хүрээнд хамаарахыг тайлбарлаж бичнэ үү.

1.....

2.....

C. Энэхүү бодлогоор монголын хойд хилээр олон иргэдийг тариа тариулан суулгах болсон шалтгааныг тодорхойлж бичнэ үү.

.....

.....

32. Дараах зургийг ажиглан асуултад хариулна уу.



A. Түүх IX, УБ., 2015.а. Түүхэн зурагт Монголын түүхийн ямар үйл явдлыг харуулсан байна вэ?

.....

B. Атрын анхдугаар аяныг хэдэн оноос өрнүүлж эхэлсэн бэ?

.....

.....

.....

C.Энэ үйл явдлыг өрнүүлснээр Монгол улсад ямар ач холбогдолтой байсныг бичнэ үү.

.....

D.Дээрх түүхэн үйл явдлыг өрнүүлснээр гарсан сөрөг үр дагаврыг тайлбарлан бичнэ үү.

.....

E.Атар газар эзэмшсэн үйл явцын түүхэн сургамжийг бичнэ үү.

.....

33. НТӨ 176 онд Модунь шаньюй Хан улсын хувьд хуандид бичсэн захидалдаа: “би, хөрш зэргэлдээ.... хол ойрын гучин зургаан их бага улс түмнийг хураан авч нэгтгэн захирлаа. Өдгөө тэд Хүннү гүрэн хэмээх нэгэн аугаа их суу алдрын дор эвсэн нэгджээ. Ийнхүү их хээр талын энгээр нүүдэллэн амьдрагч нум сумтан ард түмэн бүгд нэгэн их гэр бүлд багтаад, их хээр талд энх амгалан ёс тогтоов. Тиймийн тулд одоо би эрдэнийн илдээн хуйнд нь хуйлж дуут сумаан саадагт нь сойсугай. Түүх YI, УБ., 2015.

A. Эх сурвалжийн он цагийг тогтоогоорой.

.....

B. Эх сурвалжид юуны тухай өгүүлсэн байна вэ? 2-оос доошгүй дүгнэлт бичнэ үү

.....

.....

C. Тухайн үйл явдал Хүннү гүрэн байгуулагдсанаас хойш хэдэн жилийн дараа болсон бэ?

• Хүннү гүрэн байгуулагдсан он:

• Хүннү гүрэн байгуулагдсанаас хэдэн жилийн дараа:

34. 1206 онд Онон мөрний эхэнд болсон хуралдайгаар Монгол улсыг тунхаглан зарлаж Чингис хааныг их сууринд залсан. Тэрээр хөрш улсууддаа эрх тэгш найрсаг бодлого явуулахыг зорьж байсан хэдий ч Алтан улсын эрх баригчид Монгол улсыг хүлээн зөвшөөрөхгүйгээр үл барам алба барихыг шаардан худалдааг хаан боогдуулах болсонд их цэргийн хүчээр Алтан улсыг довтлох шийдвэр гаргасан. Чингис хаан "Алтан улсын эсрэг дайлаар орохынхоо өмнө өөрийнхөө заншлаар овооны орой дээр ганцаар гарч бүсээ тайлж хүзүүндээ ороогоод дээлийнхээ товчийг тайлан өвдөг сөгдөж ...мөргөлөө нэн их сүсэглэн үйлдэв" бидний өвөг дээдэс тэнгэр шүтлэг буюу бөөгийн шашинтай байсан учраас дайнд мордохоос уулын орой болон тусгайлан бэлдсэн овоон дээр залбирал үйлддэг. 1211 онд эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлж Алтан улсыг довтлон ялж улсаа Их Монгол улс хэмээн нэрлэх болсон. Судрын чуулган II дэвтэр

А. Чингис хаан 1206 онд ямар нэртэй газар Монголын хаанд өргөмжлөгдсөн бэ?

.....

В. Тэмүжин ямар шашин шүтдэг вэ?

.....

С. Монгол улсын зүгээс хөрш улсууддаа баримталж байсан бодлогыг бичнэ үү.

.....

Д. Чингис хаан хөрш улсууддаа явуулж байсан бодлогын хүрсэн үр дүнг бичнэ үү.

.....

Е. Чингис Алтан улсад довтолсныхоо дараа улсынхаа нэрийг Их Монгол улс хэмээн өөрчилсний шалтгааныг тайлбарлан бичнэ үү.

.....

.....

35. Мэдээллийг анхааралтай уншаад зааврын дагуу ажиллана уу.

Шинэ үндсэн хууль эн тэргүүнд улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон дэвшүүлсэн юм. БНМАУ-ын АИХ чуулган 1991 оны 11 сарын 11-нээс эхлэн уг ажлын хэсгийн боловсруулсан төслийг 76 хоног хэлэлцсэний эцэст 1992 оны 1 сарын 13-нд Монгол Улсын Үндсэн хуулийг баталлаа. Монголчууд 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудаа гадны оролцоо нэг үзэл суртлын нөлөөн дор боловсруулан батласан. Түүх IX, УБ., 2016.

А. 1992 оны үндсэн хуулийг өөрөөр юу гэж нэрлэдэг вэ? [2 оноо]

.....

В. 1960, 1992 оны хуулиудын онцлогийг дүгнэн бичнэ үү. [3 оноо]

1960 оны хууль:

.....

1992 оны хууль:

.....

С. 1992 оны үндсэн хуулийн эерэг үр дагавраас хоёроос доошгүйг бичнэ үү. [3 оноо]

1.

2.

ДҮГНЭХ ХЭСЭГ:

ХУВИЛБАР “А”

Нийт авсан оноо:	Гүйцэтгэлийн хувь:	Үр дүнгийн үнэлгээний түвшин	Шалгасан багшийн нэр, гарын үсэг

1.Оросын хаан Ижил мөрний сав газарт суурьших Торгуудын Хо өрлөгийн хүсэлтийг хүлээн авсан шалтгааныг олно уу?

- A. Хаант Орос улс өмнөд хилээ хамгаалах хүч болгон ашиглах
- B. Торгуудын нүүдлийг зогсоох
- C. Хо өрлөг Оросын хаанд их хэмжээний бэлэг сэлт өгсөн
- D. Олон адуутай ирсэн
- E. Ижил мөрний хөндийн хүн амыг нэмэгдүүлэх

2.Халхын Засаг хан, Сайн ноёны угсааны Дэгдээхэй мэргэн ахай болон Зүүнгар улсын Галдан бошогтын дүү Доржжав нарыг хэн хөнөөсөн бэ?

- A. Галдан бошогт
- B. Сэцэн хан Шолой
- C. Түшээт хан Чахундорж
- D. Манжийн хаан
- E. Аль нь ч биш

3.XVII-XX зууны эхэн үе нь Монголын түүхийн аль үе вэ?

- A. Манжийн эрхшээлийн үе
- B. Дундад зууны үе
- C. Сэргэн мандалтын үе
- D. Социализмын үе
- E. Дөчин, Дөрвөн хоёрын үе

4.1924 оны Үндсэн хуулинд Монгол улсын нэрийг юу гэж заасан бэ?

- A. Олноо өргөгдсөн Монгол улс
- B. Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард улс
- C. Гадаад Монгол улс
- D. Их Монгол улс
- E. Нармай Монгол улс

5.Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд кино дэлгэцийн урлагийн хөгжилд гарсан дэвшил нь юу байсан бэ?

- A. 1945 онд “Цогт тайж” уран сайхны кино дэлгэцнээ гарсан явдал
- B. Төв театрын тайзнаа 1934 онд “Учиртай гурван толгой” жүжгийг тоглосон явдал
- C. 1935 онд “Монгол кино” үйлдвэр байгуулагдаж, дараа жил нь “Монгол хүү”гэх анхны уран сайхны кино дэлгэцнээ гарсан явдал
- D. 1934 оны 9-р сарын 1-нээс радио нэвтрүүлэг явуулах болсон явдал
- E. Дээрх бүгд зөв

6.1934 оноос бичигтэн бүр бичиг үсэг үл мэдэх хүмүүсийг сургах компани ажил өрнүүлснээр нийт хүн амын бичиг үсгийн түвшин 1935 онд 5.6% байсан бол 1940 онд 20.8% болж нэмэгдсэн нь хэдэн хувиар өссөн үзүүлэлт вэ?

- A. 17%
- B. 39%
- C. 11%
- D. 16.5%
- E. 15.2%

7.1932 оны 6-р сарын 29-30-ны хооронд болсон МАХН-ын Төв хороо, Хянан байцаах төв комиссын хамтарсан онц III бүгд хурлаар БНМАУ-ын хөгжлийн чиг хандлагыг юу гэж тодорхойлсон бэ?

- A. Үндэсний ардчилсан чиг шугамаар хөгжих
- B. ЗОУ-ын хөгжлийн загвараар хөгжих
- C. Капиталист бус хөгжлийн замаар хөгжих
- D. Социалист чиг хандлагаар хөгжих
- E. Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх

8.1945 оны дундуур Хятадын засгийн газар Монголын тусгаар тогтнолыг ямар тохиолдолд хүлээн зөвшөөрнө гэж ЗХУ-тай тохиролцсон бэ?

- A. Японы эсрэг дайнд БНМАУ идэвхтэй оролцвол
- B. АНУ, Их Британи хоёр БНМАУ-тай дипломат харилцаа тогтоовол
- C. Монголын ард түмэн бүх нийтээр тусгаар тогтнолоо дэмжвэл
- D. Улсын Бага хурлын төлөөлөгчид нь тусгаар тогтнолоо дэмжвэл
- E. БНМАУ Өвөр Монголыг өөртөө нэгтгэхгүй гэдгээ амлавал

9. Доорх хүмүүсийн нэрс юуг илэрхийлж байна вэ?

- C.Данзан, Д.Бодоо, Д.Чагдаржав, Д.Лосол, Д.Догсом, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан
- A. Ардын их хурлын тэргүүлэгчид
- B. Ардын Засгийн газрын анхны сайд нар
- C. МАН-ын Төв хорооны анхны гишүүд
- D. ЗОУ-аас тусламж гуйхаар явсан нууц бүлгэмийн төлөөлөгчид
- E. Зүүн хүрээний бүлгэмийн гишүүд

10. Судар бичгийн хүрээлэнгийн анхны эрдэмтдэд хэн нь хамаарахгүй вэ?

- A. С.Жамьян
- B. Д.Нацагдорж
- C. Ж.Цэвээн
- D. Б.Буянчуулган
- E. Л.Дэндэв

- 11.1922 оны 1-р сарын 25-нд Ардын засгийн газраас эзэн хамжлагын харилцааг халах шийдвэр гаргаж, хамжлагат ёсыг ямар үйл явдлаар халсан бэ?**
- A. Үндсэн хууль баталснаар
 - B. Тангаргийн гэрээг батлан мөрдүүлснээр
 - C. Ноёд тайж нарын хөрөнгийг хураан авснаар
 - D. Ноёд тайж нарын хамжлага захирах эрхийг цуцалж, тамгын хураан авснаар
 - E. Монгол улсын нутгийн захиргааны дүрэм батлагдсанаар
- 12.1924 оны Үндсэн хуулийн шинэ төслийг боловсруулсан комиссын гишүүдийг сонгоно уу?**
- A. Н.Магсаржав, Ж.Цэвээн, Ч.Бат-Очир
 - B. П.Всесвятский, А.Бурдуков, И.Майский
 - C. Н.Магсаржав, Д.Бодоо, П.Всесвятский
 - D. Б.Цэрэндорж, А.Амар, Н.Жадамба
 - E. Б.Цэрэндорж, Ж.Цэвээн, Э.Ринчино, П.Всесвятский
- 13.Буган хөшөөний дунд хэсэгт бугыг хэрхэн дүрсэлсэн байдаг вэ?**
- A. Хэвтэж буй байдлаар
 - B. Зөвхөн бодит байдлаар
 - C. Улаан зосоор загварчлан
 - D. Бодитоор болон загварчлан
 - E. Сүрлэг томоор
- 14.Монгол орон жилийн дөрвөн улиралтай, эрс тэс хуурай уур амьсгалтай тул газар тариалан, суурин аж ахуй хөгжих боломж хязгаарлагдмал байдаг нь юуг илэрхийлж байна вэ?**
- A. Монгол орны цаг уур, байгаль газар зүйн онцлог нь нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтойг
 - B. Эрс тэс уур амьсгал нь суурин аж ахуйд тохирдоггүйг
 - C. Өвс ургамал бага ургадаг болохыг
 - D. Монгол орон хуурай халуун уур амьсгалтайг
 - E. Газар тариалан, мал аж ахуй зэрэг хөгжих боломжгүйг
- 15.Модунь шаньюйн түүхэн гол үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ?**
- 1. Өмнөд хөрш Хан улс руу довтлов.
 - 2. Улсаа баруун, зүүн, төв гэсэн гурван хэсэгт хуваан захирав.
 - 3. Хүннүгийн шаньюй болов.
- A. 1, 2, 3
 - B. 2, 1, 3
 - C. 3, 2, 1
 - D. 3, 1, 2
 - E. 2, 3, 1
- 16.Лигдэн хааны дотоод бодлогын үйл ажиллагаанд аль нь хамаарахгүй вэ?**
- A. Мин улстай хилийн худалдаа хийж, татаас авч байв.
 - B. Авга хар уул гэдэг газар Очир Цагаан хот байгуулав.
 - C. Бурхан шашны хөлгөн судар 108 боть “Ганжуур”-ыг орчуулуулав.
 - D. Цахар түмнийг зүүн, баруун, төв гэсэн гурван түмэн болгон хуваан захирав.
 - E. Төвөдийн Улааны лам Ширваа хутагтыг “Улсын багш” болгов.
- 17.XVI зууны үед Монгол гэрийн төрх, хэлбэр, хэмжээ нь эрт, дундад үеийнхээс өөрчлөгдөж, одоогийн төрхийг олжээ. Тэгвэл гэрийн хэлбэрт ямар өөрчлөлт гарсан бэ?**
- A. Монгол гэр бөмбөгөр, дугуй хэлбэртэй болсон
 - B. Гэрийн хаалганы хавтсыг модоор хийдэг болсон
 - C. Хаад ноёд гоёмсог сийлбэр бүхий гэр хэрэглэх болсон
 - D. Гэрийн гадна талыг хээ угалзаар чимэглэх болсон
 - E. Ханын толгой нэмэгдэж, цамхраат тооно бий болсон
- 18. Өвөр монголчуудаас Манжийн цэрэгтэй нийлж, Лигдэн хааны цэргийг бут цохиход оролцоогүй аймаг аль нь вэ?**
- A. Цахар
 - B. Хорчин
 - C. Түмэд
 - D. Ордос
 - E. Юншээбү
- 19.Их Монгол улсын алтан ургийн “Их эе”-ийн хэлэлцэх асуудалд аль нь орохгүй вэ?**
- A. Төрийн чухал асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах
 - B. Дайн хийх
 - C. Их хааны залгамжлагчийг сонгох
 - D. Найрамдах
 - E. Аравтын ноёдыг томилох
- 20.Монголын Ил хаант улсын газар нутаг нь одоогийн ямар ямар улсын газар нутгийг хамарч байсан бэ?**
- A. Азербайжан, Казакстан, Иран, Орос
 - B. Казакстан, Узбек, Киргиз, Тажик
 - C. Азербайжан, Армен, Гүрж, Афган, Иран, Ирак
 - D. Монгол, Хятад, Солонгос, Бирм, Аннам
 - E. Афганстан, Пакистан, Египэт, Армен

21. Монголын Их Юань улсын үед “Монгол хүнийг тэргүүнд тавьж, дараа нь өнгөт нүдтэн хэмээгдэх уйгур, араб, перс хүмүүсийг, гуравт умард Хятад дахь зүрчид, хятан нар, хамгийн доор өмнөд хятадын нанхиад нар” гэсэн дөрвөн зэрэглэлд хүн амаа хуваасны шалтгаан юу вэ?

- A. Буддын шашны хос ёсны бодлогоор
- B. Төрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор
- C. Улсын дотоод эв нэгдлийг хангах үүднээс
- D. Монголчууд бусад үндэстнээс олон байсан
- E. Үндэстэн хоорондын мөргөлдөөнөөс сэргийлж

22. Монгол орон жилийн дөрвөн улиралтай, эрс тэс хуурай уур амьсгалтай тул газар тариалан, суурин аж ахуй хөгжих боломж хязгаарлагдмал байдаг нь юуг илэрхийлж байна вэ?

- A. Монгол орны цаг уур, байгаль газар зүйн онцлог нь нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтойг
- B. Эрс тэс уур амьсгал нь суурин аж ахуйд тохирдоггүйг
- C. Өвс ургамал бага ургадаг болохыг
- D. Монгол орон хуурай халуун уур амьсгалтайг
- E. Газар тариалан, мал аж ахуй зэрэг хөгжих боломжгүйг

23. Модунь шаньюйн түүхэн гол үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ?

- 1. Өмнөд хөрш Хан улс руу довтлов.
- 2. Улсаа баруун, зүүн, төв гэсэн гурван хэсэгт хуваан захирав.
- 3. Хүннүгийн шаньюй болов.

- A. 1, 2, 3
- B. 2, 1, 3
- C. 3, 2, 1
- D. 3, 1, 2
- E. 2, 3, 1

24. Хүннүгийн хууль цаазын тухай Хятад сурвалжид “тэдний баримталдаг хуулиар ирт үзүүртийг гаргавал цаазаар аваачна, хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөнийг бэрээднэ, хүндийг цаазаар авна” хэмээх мэдээний гол агуулгыг зөв тодорхойлсон нь аль вэ?

- A. Их Засаг хуулийг Хүннүгийн үед зохиосон
- B. Хүннү улс өөрийн гэсэн хууль цаазтай байсан
- C. Хүннү улсын хуулийг Хятад хуулчид хуулж бичдэг байсан
- D. Хүннүгийн хууль Хятадын Хан улсын хуультай төстэй байсан
- E. Хүннү улс цаазын түшмэлтэй байсан

25. Сяньби улс хүчирхэг байсныг нотлох сурвалжийн мэдээ аль нь вэ?

- A. Тэдний зэвсгийн хурц, морины хурдан нь Хүннү нарынхаас нэн хэтийджээ.
- B. Малынхаа тоог өсгөж, үүлдэр угсааг нь сайжруулж байв.
- C. Умард Хүннүгийн зарим хүн амыг өөртөө нэгтгэжээ.
- D. Гар урлал, газар тариалан эрчимтэй хөгжиж байв.
- E. Сяньби улсын цэргийн тоо 500.000-д хүрчээ.

26. 47. 2019 оны 10-р сарын 27-нд Монгол улс НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болсны хэдэн жилийн ой тохиох вэ?

- A. 73
- B. 58
- C. 60
- D. 65
- E. 56

27. Монгол улс НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болсныхоо дараа дэлхий дахинд тулгамдсан асуудлуудаас ямар чиглэлд идэвхтэй оролцож байсан бэ?

- A. Хүлэмжийн хийн хэмжээг бууруулах
- B. Байгаль орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал
- C. Улс түмнүүдийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох
- D. Тогтвортой хөгжлийг хангах
- E. Шашин хоорондын мөргөлдөөнийг зогсоох

28. Монголын Ардчилсан холбооны анхны зохицуулагч хэн байсан бэ?

- A. С.Зориг
- B. Э.Бат-Үүл
- C. Ц.Элбэгдорж
- D. Р.Амаржаргал
- E. Д.Дорлигжав

29. 1990 оны 5-р сард батлагдсан “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн ач холбогдол нь юу вэ?

- A. МАХН-ын Улс төрийн товчоог огцоруулав.
- B. Монголын Ардчилсан нам байгуулагдав.
- C. Улсын бага хурлыг байгуулав.
- D. Ерөнхийлөгчийн албан тушаалыг бий болгов.
- E. Монголд олон намын тогтолцоо бий болов.

30. 1990 оны анхны олон намын оролцоотой, чөлөөт ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Бага хурал хэдэн хүний бүрэлдэхүүнтэй болсон бэ?

- A. 357
- B. 422
- C. 76
- D. 50
- E. 32

ЗАДГАЙ ДААЛГАВАР :

31. Дараах эх сурвалжийг анхааралтай уншиж асуултад хариулна уу.

“... цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн буюу 1911 оны XII сарын 29-ний баасан гаригт Монголын шарын шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагтыг Монгол улсын шашин, төрийг хослон барьсан хаан ширээнд өргөмжлөн залах ёслол Их Хүрээнд болж, Олноо өргөгдсөн Монгол улсыг байгуулсныг албан ёсоор тунхаглав. Энэхүү хувьсгалаар Монголчууд 200 гаруй жилийн харийн эрхшээлээс ангижран өөрийн тусгаар улсаа байгуулсан гэдгээ дэлхийн улсуудад зарлан мэдэгдэв. Богд хааны зарлигаар Монгол улсын Засгийн Газрыг 5 яамтайгаар байгуулж, Монголын тусгаар тогтнолын төлөө идэвхтэй хүчин зүтгэгчдийг төрийн удирдах албан тушаалд томилж, зэрэг хэргэм шагнаснаас гадна хөгшин настайчуудад мөнгө, таяг зэргийг тус тус шагнан хүртээж, хүнд хөнгөн ялтныг өршөөж, бүрнээ хэлтрүүлэн суллаж тавив. Түүх IX, УБ., 2015.

a. Олноо өргөгдсөн Монгол улсын Засгийн газрын Ерөнхий сайдыг хэн гэдэг байсан бэ?

.....

b. Тусгаар тогтнолоо зарласан Монгол улсын нийслэлийн нэрийг хэрхэн нэрлэдэг байсан бэ?

.....

c. Монголчууд яагаад хувьсгал хийх болсон бэ?

.....

D.1911 оны үндэсний хувьсгалын ач холбогдол юу байсныг тайлбарлан бичнэ үү

.....

32. Дараах зургийг ажиглан асуултад хариулна уу.



a. Энэхүү хөшөө ямар үйл явдлыг өгүүлдэг вэ?

.....

b. Монголын түүхэнд дэх хэлмэгдүүлэлт хэдэн оноос эхэлсэн гэж үздэг вэ?

.....

c. Жил бүрийн хэдэн сарын хэдэнд дээрх хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүлдэг вэ?.....

d. “Онцгой бүрэн эрхт комисс” гэдэг нь ямар үйл ажиллагаа гүйцэтгэдэг байсан бэ?

.....

e. Хэлмэгдүүлэлт бидэнд ямар хор уршиг үлдээсэн бэ?

.....

33. “...Эртний хүний бууц Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, мөн аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Ховд аймгийн Алтай сумын Барилгийн гол, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул, мөн аймгийн Хулд сумын төвийн дэргэд, Дэлгэрцогт сумын Ёроол говь, Дорноговь аймгийн Сайншандын орчим зэрэг нэлээд газраас олджээ. Хуучин чулуун зэвсгийн үед хүн байгаль дээр байгаа зэрлэг ан амьтан, загас, идэж болохоор үр жимс, ус эрж хайн нэг газраас нөгөөд байнга нүүдэллэн амьдарч байв. Эртний хүмүүсийн амьдралд маш их өөрчлөлт гарсан үеийг түүхэнд шинэ чулуун зэвсгийн хувьсгал гэж нэрлэдэг”Түүх VI, УБ., 2015.

a. Хүн төрөлхтний түүхэнд хамгийн удаан хэрэглэгдсэн багаж зэвсгийн материал юу вэ?

.....

b. Монгол нутагт хэдэн мянган жилийн тэртээгээс хүн суурьшин амьдрах болсон бэ?

.....

c. Өгөгдлүүдээс оновчтойг нь сонгоно уу.

A. Монгол нутагт 80 мянган жилийн өмнөөс хүн оршин амьдарч байсан нь тогтоогдсон.

B. Монгол нутагт 800 мянган жилийн өмнөөс хүн оршин амьдарч байсан нь тогтоогдсон.

C.Монгол нутагт хуучин чулуун зэвсгийн үеэс бусад бүх үеийн дурсгал бий.

D. Монгол нутаг далайгаас алс хол учир хэзээ ч чийглэг дулаан уур амьсгалтай байсангүй.

d. Неолитийн хувьсгал гэж юу хэлэх вэ?

.....

34. Чингис хаан Тангуд улсыг 1205, 1207, 1209 онуудад довтлон дайнд баруун гар болон оролцох үүрэг хүлээлгэсэн. 450 хүний бүрэлдэхүүнтэй монголын худалдааны нүсэр том анги Хорезм улс тийш хөдөлжээ. Чингис хаан “эвийн гэрээ байгуулж, хөршийн харилцаа барьж худалдаагаа өргөжүүлбэ” гэдэг саналаа давтан хэлүүлсэн. 1218 оны хавар монголын худалдаачид захын хот Отрарт очиход хотын дарга Инальчик хан монголоос ирсэн худалдаачдын эд бараанд шунаж хувьдаа хураан авах муу арга сүвэгчлэн элч худалдаачидыг хороосонд “... Чингис хаан Сартуул иргэнээ, Ухуна тэргүүтэн зуун элчээ зэтгэгдэж(хоригдож) алагдаж, Чингис хаан өгүүлрүүн Алтан аргамжаа сартуул иргэнд яахин таслуулах бүлгээ” хэмээгээд Тангуд морил хэмээж илгээвээс “хүч ядах бөгөөтөл хаан юунд болов” хэмээн их үг өгүүлж илгээжээ. Чингис хаан Хорезм улсыг дайлаар мордохын өмнө өөрийн хаан ширээ залгамжлагчаа сонгосон. Монголын нууц товчоо

а. Хорезмыг дайлаар мордохоос өмнө хаан ширээ залгамжлагчаар хэнийг тодруулсан бэ?

б. Тангуд улсын бурхныг хэд хэдэн онуудад довтлон буулт хийлгэсэн бэ?

в. Хэдээс хэдэн оны хооронд Сартуулын нутгаар аян дайн өрнүүлсэн бэ?

д. Энэхүү аян дайны үр дүнд Их Монгол улсын газар нутаг баруун талын зах нь хаагуур зааглагдах болсон бэ?

е. Алтан аргамж хэмээх үгийг тайлбарлана уу.

35. Дараах эх сурвалжийг анхааралтай уншиж асуултад хариулна уу.

“...БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбатаар ахлуулсан Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах комиссын удирдлагаар төсөл боловсруулах ажлын хэсгийн боловсруулсан ба эрдэмтэн судлаачдын санал болгосон хувилбарууд, дэлхийн ардчилсан улс орнуудын Үндсэн хуулийн жишиг, гадаад, дотоодын зөвлөх, мэргэжилтнүүдийн санал дүгнэлт зэргийг харьцуулан нягталсны үндсэн дээр боловсруулсан төслийг УБХ /Улсын бага хурал/ ард түмнээр хэлэлцүүлэх шийдвэр гаргасан байна. Үндсэн хуулийн төслийг 7 мянга гаруй байгууллага, хамт олон хэлэлцэж, түүнд 900 мянга гаруй хүн оролцож, 200 мянга гаруй санал гарчээ. Төслийг УБХ 2 удаа хэлэлцэж, АИХ /Ардын их хурал/-д оруулжээ. АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан нийт 76 хоног хуралдсан бөгөөд Шинэ Үндсэн хуульд урьд нь үйлчилж байсан Үндсэн хуулийн нэмэлтийн хуульд тусгалаа олсон улс төрийн ардчилсан тогтолцооны тулгуур зарчмуудыг уламжлахын зэрэгцээ олон шинэ үндэслэлүүдээр түүнийг баяжуулж, Монгол Улсад нэг шаттай парламент, Ерөнхийлөгчийн институт бүхий Бүгд найрамдах засаглалын ардчилсан хэлбэрийг хуульчлан баталгаажуулсан юм.”

а. Монгол улсад Ардчилсан шинэ үндсэн хуулийг хэзээ баталсан бэ?

б. Монгол улсад хэдэн онд анх удаа бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль болсон бэ?

в. Үндсэн хуулийн төслийг олон мянган хүнээр шүүлгэн хэлэлцүүлсний учир юу вэ?

д. Ардчилсан сонгуулийн онцлогийг бичнэ үү.

е. Шинэ үндсэн хуулийн ач холбогдолыг тайлбарлан бичнэ үү.

ДҮГНЭХ ХЭСЭГ:

ХУВИЛБАР “Б”

Нийт авсан оноо:	Гүйцэтгэлийн хувь:	Үр дүнгийн үнэлгээний түвшин	Шалгасан багшийн нэр, гарын үсэг